Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баян-Өлгий аймгийн Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/04/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Х.Манаргүл<br>Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын санал дүгнэлт ....................................................... **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................................................... 3
3. Аудитын тайлан ....................................................... 11
3.1 Ерөнхий зүйл ....................................................... 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....................................................... 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................................................... 11
3.4 Материаллаг байдал ....................................................... 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....................................................... 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....................................................... 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....................................................... 13
3.8 Аудитын гол асуудал ....................................................... 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................................... 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................................................... 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................................................... 14
4. Аудитын илрүүлэлт ....................................................... 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................................................... 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

Төсвийн захирагч

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ОЛОН
НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН ДАРГА
Н.ОСПАН ТАНАА

2022.02.02 № 11
танай ______ -ны № ______ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Орон нутгийн олон нийтийн радио телевизийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орон нутгийн олон нийтийн радио телевизийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,493,105.00** | **1,746,605.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,493,105.00 | 1,746,605.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 1,493,105.00 | 1,746,605.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 541,900.00 | 654,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 435,100.00 | 575,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 516,105.00 | 516,105.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **225,355,098.85** | **216,681,964.15** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 225,355,098.85 | 216,681,964.15 |
| **392** | **Биет хөрөнгө** | 225,355,098.85 | 216,681,964.15 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 206,882,686.00 | 206,882,686.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (9,157,945.20) | (12,605,989.92) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 9,800,000.00 | 9,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,633,333.32) | (3,266,666.64) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 95,650,752.40 | 99,250,752.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (80,694,655.33) | (86,137,771.95) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17,196,204.00 | 17,196,204.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,688,609.70) | (14,437,249.74) |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **226,848,203.85** | **218,428,569.15** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,849,746.25** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,849,746.25 | - |
| **413** | **Өглөг** | 2,849,746.25 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,849,746.25 | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **465,138,240.90** | **459,568,352.45** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 465,138,240.90 | 459,568,352.45 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 48,928,941.00 | 48,928,941.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 48,928,941.00 | 48,928,941.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 175,069,516.60 | 169,499,628.15 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (66,070,266.70) | (66,070,266.70) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (5,569,888.45) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 241,139,783.30 | 241,139,783.30 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **467,987,987.15** | **459,568,352.45** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **297,455,523.00** | **274,824,352.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,735,523.00** | **44,365,752.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 27,735,523.00 | 44,365,752.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 27,735,523.00 | 44,365,752.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,506,500.00 | 22,774,552.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,229,023.00 | 21,591,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **269,720,000.00** | **230,458,600.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 269,720,000.00 | 230,458,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 269,720,000.00 | 230,458,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **303,173,884.67** | **280,394,240.45** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **303,173,884.67** | **280,394,240.45** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 277,438,384.67 | 271,638,844.45 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 207,727,444.00 | 205,340,566.00 |
| 210101 | Үндсэн цалин | 159,721,844.00 | 154,546,499.00 |
| 210102 | Нэмэгдэл | 48,005,600.00 | 50,794,067.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,364,500.00 | 26,646,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,312,800.00 | 18,551,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,012,900.00 | 2,023,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,610,300.00 | 1,619,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 402,600.00 | 404,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,025,900.00 | 4,047,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,013,046.25 | 20,352,443.75 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,781,505.00 | 1,755,672.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,151,541.25 | 17,516,771.75 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,080,000.00 | 1,080,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,224,317.00 | 3,649,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,069,700.00 | 785,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,417,700.00 | 1,714,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,155,717.00 | 806,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 581,200.00 | 343,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,888,406.00 | 717,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,297,856.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 100,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 5,490,550.00 | 717,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 180,000.00 | 720,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 180,000.00 | 720,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,826,800.00 | 1,939,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,438,800.00 | 1,565,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 36,000.00 | 30,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 32,000.00 | 26,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 16,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,213,871.42 | 12,273,134.70 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,213,871.42 | 12,273,134.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 25,735,500.00 | 8,755,396.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,760,000.00 | 1,320,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,000,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 760,000.00 | 1,320,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,975,500.00 | 7,435,396.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,975,500.00 | 7,435,396.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | (5,718,361.67) | (5,569,888.45) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | (5,718,361.67) | (5,569,888.45) |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **48,928,941.00** | **241,139,783.30** | **(66,070,266.70)** | **223,998,457.60** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **48,928,941.00** | **241,139,783.30** | **(66,070,266.70)** | **223,998,457.60** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (5,569,888.45) | (5,569,888.45) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **48,928,941.00** | **241,139,783.30** | **(71,640,155.15)** | **218,428,569.15** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **297,455,523.00** | **274,824,352.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,735,523.00** | **44,365,752.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 27,735,523.00 | 44,365,752.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 27,735,523.00 | 44,365,752.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,506,500.00 | 22,774,552.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,229,023.00 | 21,591,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **269,720,000.00** | **230,458,600.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 269,720,000.00 | 230,458,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 269,720,000.00 | 230,458,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **290,623,623.00** | **271,224,352.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **290,623,623.00** | **271,224,352.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **264,888,123.00** | **262,468,956.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 209,293,000.00 | 205,340,566.00 |
| 210101 | Үндсэн цалин | 161,287,400.00 | 154,546,499.00 |
| 210102 | Нэмэгдэл | 48,005,600.00 | 50,794,067.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,364,500.00 | 26,646,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,312,800.00 | 18,551,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,012,900.00 | 2,023,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,610,300.00 | 1,619,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 402,600.00 | 404,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,025,900.00 | 4,047,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,163,300.00 | 23,202,190.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,781,505.00 | 1,755,672.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,301,795.00 | 20,366,518.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,080,000.00 | 1,080,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,172,117.00 | 3,903,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 905,000.00 | 896,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,530,200.00 | 1,715,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,155,717.00 | 806,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 581,200.00 | 484,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,888,406.00 | 717,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,297,856.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 100,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 5,490,550.00 | 717,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 180,000.00 | 720,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 180,000.00 | 720,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,826,800.00 | 1,939,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,438,800.00 | 1,565,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 36,000.00 | 30,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 32,000.00 | 26,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 16,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **25,735,500.00** | **8,755,396.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,760,000.00 | 1,320,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,000,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 760,000.00 | 1,320,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,975,500.00 | 7,435,396.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,975,500.00 | 7,435,396.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **6,831,900.00** | **3,600,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **6,831,900.00** | **3,600,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,831,900.00** | **3,600,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 6,831,900.00 | 3,600,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,831,900.00 | 3,600,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(6,831,900.00)** | **(3,600,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 252,458,600.00 | 252,458,600.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 252,458,600.00 | 252,458,600.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 252,458,600.00 | 252,458,600.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 202,384,600.00 | 202,384,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 154,379,000.00 | 151,590,533.00 |
| 210102 | Нэмэгдэл | 48,005,600.00 | 50,794,067.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,646,900.00 | 26,646,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,551,500.00 | 18,551,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,023,800.00 | 2,023,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,619,100.00 | 1,619,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 404,800.00 | 404,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,047,700.00 | 4,047,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,057,700.00 | 18,057,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,639,400.00 | 1,755,672.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,479,100.00 | 15,222,028.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,939,200.00 | 1,080,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,709,300.00 | 2,709,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 583,300.00 | 583,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 800,000.00 | 835,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 841,700.00 | 806,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 484,300.00 | 484,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,666,700.00 | 1,666,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,666,700.00 | 1,666,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 720,000.00 | 720,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 720,000.00 | 720,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 273,400.00 | 273,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 30,000.00 | 30,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 26,700.00 | 26,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16,700.00 | 16,700.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 252,458,600.00 | 252,458,600.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 230,458,600.00 | 230,458,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 230,458,600.00 | 230,458,600.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 22,000,000.00 | 22,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,000,000.00 | 22,000,000.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 20 | 20 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18 | 18 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | 1 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **20.00** | **20.00** |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 20.00 | 20.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **15,229,023.00** | **14,930,356.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **15,229,023.00** | **14,930,356.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 14,469,023.00 | 13,610,356.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | 2,955,966.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 2,955,966.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 5,144,490.00 |
| 210302 | Түлш, халаалт | | 5,144,490.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 735,917.00 | 1,193,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 260,000.00 | 313,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 330,200.00 | 880,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 145,717.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,234,306.00 | 2,650,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,207,756.00 | 1,933,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 100,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 7,926,550.00 | 717,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,498,800.00 | 1,665,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,438,800.00 | 1,565,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 60,000.00 | 100,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 760,000.00 | 1,320,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 760,000.00 | 1,320,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 760,000.00 | 1,320,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 15,229,023.00 | 21,591,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,229,023.00 | 21,591,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,229,023.00 | 21,591,200.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Орон нутгийн олон нийтийн радио телевизийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн зорилго нь: Орон нутагт олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг, хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн байгууллага бий болгох Үнэт зүйлс Чөлөөт иргэд Чөлөөт хэвлэл Чөлөөт сэтгүүлчид

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна.Үүнд:

Орон нутагт мэргэжлийн сэтгүүлзүйг бий болгож, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэн, нийт үндэсний эрх ашгийг дээдэлсэн, улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, өв соёл, зан заншил, урлаг, спортын өргөн хүрээг хамарсан, нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн нэвтрүүлэгүүдийг олон нийтийн хүртээл болгох

Орон нутгийн иргэдэд төрийн бодлогыг ойртуулж, сонсогчдыг хууль тогтоомж, цаг үеийн мэдээллээр хангах, иргэдэд орон нутагт болж байгаа үйл явдал тухай мэдээ, мэдээлэл хүргэх, иргэдийг соён гэгээрүүлэх, сонсогч, үзэгчдэд зориулсан төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, хөгжөөн цэнгээх хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгож ажиллах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Орон нутгийн олон нийтийн радио телевиз нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд ямар нэгэн шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орон нутгийн олон нийтийн радио телевизийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 303.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орон нутгийн олон нийтийн радио телевизийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.4 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 1,493.1 | 1,746.6 | 253.5 |
| Үндсэн хөрөнгө | 225,355.1 | 216,682.0 | (8,673.1) |
| **Нийт хөрөнгө** | **226,848.2** | **218,428.6** | **(8,419.6)** |
| Өр төлбөр | 2,849.7 | - | (2,849.7) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 223,998.5 | 218,428.6 | (5,569.9) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **226,848.2** | **218,428.6** | **(8,419.6)** |

Мөнгөн хөрөнгө, авлагын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1.7 сая төгрөг болж 0.3 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 3.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч. 3,3 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө 8.7 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 3.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, үндсэн хөрөнгөнд 12.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Оны эхний 2.8 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, оны эцэст өглөггүй гарсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 218.4 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 5.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орон нутгийн олон нийтийн радио телевизийн 2021 оны төсвийг 252.4 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсвөөс 252.4 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч үйл ажиллагаанд 252.4 сая төгрөг зарцуулж төсөвтөө багтаан ажилласан байна. Орон нутгийн төсвөөс 230.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 22.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөнөөс давсан 0.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зарлагын 90.7 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 9.9 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоос 21.6 сая төгрөг оруулсаныг байгууллагын нэмэлт дансаар хүлээн авч, 15.0 сая төгрөгийг зөвшөөрлийн дагуу зарцуулж, 6.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтээс зарцуулсан зардлыг задалж үзэхэд түлш халаалтын зардалд 5.1 сая, тээвэр шатахуунд 0.9 сая, ажиллагсадтай холбоотой зардалд 3.0 сая, тоног төхөөрөмж худалдан авахад 1.9 сая, бусад зардалд 4.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Орон нутгийн олон нийтийн радио телевизийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 205,4 сая төгрөг, НДШ-ийн зардалд 26,6 сая төгрөг, халаалтын зардалд 20,3 сая төгрөг, урсгал засварын зардалд 0.7 сая төгрөг, нийтдээ 253,0 сая төгрөг зарцуулсан байна.

Нийт санхүүжилт болон нэмэлт дансны орлого болох 274,8 сая төгрөгнөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 21,8 сая төгрөгийн

зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 2,2 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба оны эцэст 7,4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдсан гэж үзлээ.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орон нутгийн олон нийтийн радио телевиз нь 2021 онд нийт 230.4 сая төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 230.4 сая төгрөгийн 173 мэдээллийг хугацаандаа байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ гараагүй, харин өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулаагүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нэг акт тогтоосныг барагдуулж, шилэн данстай холбоотой зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил гараагүй болно.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">д/д</th><th rowspan="3">Аудитад хамрагдсан байгууллагын нэр</th><th colspan="2" rowspan="2">Нийт алдаа, зөрчлийн</th><th colspan="8">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Залруулга</th><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>